

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА

ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-НИЙ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishiqjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай Аудит” ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ААНБОАТ	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэл
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
БҮТЭЗ	Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

1.Аудитын санал дүгнэлт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/2022
танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аудитын гол асуудлууд хэсэгт дурдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Бид санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах үзэл баримтлалын хамрах хүрээ нь зөвхөн санхүүгийн тайлангуудыг авч үзсэн. Үүнээс болоод суурь үзэл баримтлалынх нь хамрах хүрээ илүү өргөн болсон. Энэхүү санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд 106.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа анхан шатны баримтыг олгосон, хүлээн авсан гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж, бүртгэж тайлагнасан, цалингийн зардлыг батлагдсан зорилтод түвшнээс 73.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан өмчийн дүнг 60.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт

19020404

D 2022/2022 он/ALBAN BICHIG

нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Оршин байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудал

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх ба эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	33,862,903.92	38,004,163.26
1.1.2	Дансны авлага	19,085,932.00	19,085,932.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,029,830.27	13,920,853.37
1.1.4	Бусад авлага	13,905,184.11	5,510,189.44
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	85,101,833.42	25,656,186.27
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.10	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	152,985,683.72	102,177,324.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	638,048,834.44	598,934,026.42
1.2.2	Биет бус хөрөнгө	40,768,458.33	40,619,708.33
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	678,817,292.77	639,553,734.75
1.3	Нийт хөрөнгийн дүн	831,802,976.49	741,731,059.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	19,763,374.78	184,221,899.85
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр	57,729,937.08	39,454,054.26
2.1.1.4	НДШ - ийн өглөг	28,161,678.44	109,483,155.59
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	105,654,990.30	333,159,109.70
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	105,654,990.30	333,159,109.70
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.1	-төрийн	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,244,498.98	25,244,498.98
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	40,270,000.00	40,270,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(358,275,341.20)	(675,851,377.99)
2.3.11	Эздийн өмчийн дүн	726,147,986.19	408,571,949.40
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	831,802,976.49	741,731,059.10

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,844,215,192.73	942,896,172.73
2	Борлуулалтын өртөг	1,143,855,907.26	988,814,400.06
3	Нийт ашиг (алдагдал)	700,359,285.47	(45,918,227.33)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	137,854.55	8,181,818.18
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	846,844,257.08	239,761,082.73
11	Санхүүгийн зардал	-	1,528,335.00
12	Бусад зардал	31,919,700.53	13,715,774.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(178,266,817.60)	(292,741,601.37)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(178,266,817.60)	(292,741,601.37)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(178,266,817.60)	(292,741,601.37)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(178,266,817.60)	(292,741,601.37)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(161,688,163.15)	922,735,164.24
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(18,320,360.46)	(18,320,360.46)
2	Залруулсан үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(180,008,523.61)	904,414,803.78
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(178,266,817.59)	(178,266,817.59)
4	Бусад дэлгэрэнгүй орлого					-
5	Өмчид гарсан өөрчлөлт					-
6	Зарласан ногдол ашиг				-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(358,275,341.20)	726,147,986.19
1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл				(24,834,435.42)	(24,834,435.42)
2	Залруулсан үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(383,109,776.62)	701,313,550.77
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(292,741,601.37)	(292,741,601.37)
4	Бусад дэлгэрэнгүй орлого					-
5	Өмчид гарсан өөрчлөлт					-
6	Зарласан ногдол ашиг					-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(675,851,377.99)	408,571,949.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	2,119,320,151.00	1,047,904,486.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,109,441,129.00	1,047,628,813.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,570,436.00	255,673.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,308,586.00	20,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,126,736,699.03	1,041,631,626.66
1.2.1	Ажиллагчдад төлсөн	511,948,365.17	410,118,460.76
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	142,843,892.91	58,161,678.44
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	323,271,838.50	238,177,035.83
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	1,845,219.23
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	698,000.00	129,325,340.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,906,315.43	1,528,335.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	166,623,972.77	135,874,908.71
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	857,025.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	978,444,314.25	65,743,623.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,416,548.03)	6,272,859.34
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	500,000.00	1,950,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	500,000.00	1,950,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	19,253,427.27	4,081,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,253,427.27	4,081,600.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(18,753,427.27)	(2,131,600.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	31,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		31,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	20,630,000.00	31,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		31,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	20,630,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,630,000.00)	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(46,799,975.30)	4,141,259.34
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	80,662,879.22	33,862,903.92
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	33,862,903.92	38,004,163.26

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</i>		1,844,353.6	1,867,272.8	951,078.0	916,194.8	50.9
	Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	1,844,215.7	1,812,727.3	942,896.2	869,831.1	52.0
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	мян.төг	137.9	54,545.5	8,181.8	46,363.7	15.0
2	Нийт орлого	мян.төг	1,844,353.6	1,867,272.8	951,078.0	916,194.8	50.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,844,353.6	1,867,272.8	951,078.0	916,194.8	50.9
3	Нийт зардал	мян.төг	2,022,619.9	1,855,523.3	1,213,819.6	641,703.7	65.4
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	846,844.3	305,734.6	239,761.1	65,973.5	78.4
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(178,266.3)	11,749.5	(262,741.6)	274,491.1	(2,236.2)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	-	10,574.6	-	10,574.6	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	307,267.4	298,790.3	223,695.3	75,095.0	74.9
	а/ Орлогын татварт	мян.төг	17,158.4	1,174.9	11,823.6	(10,648.7)	1,006.3
	б/ НӨАТ	мян.төг	102,732.3	135,801.6	96,243.7	39,557.9	70.9
	в/ НДШ	мян.төг	142,843.9	125,771.8	58,161.7	67,610.1	46.2
	г/ Хүн амын орлогын албан татвар	мян.төг	39,839.4	31,422.5	46,036.7	(14,614.2)	146.5
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	2,918.1	2,918.0	2,012.6	905.4	69.0
	е/ Гаалийн татвар	мян.төг	-	-	-	-	#DIV/0!
	ж/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,027.2	951.5	1,067.8	(116.3)	112.2
	з/ Бусад татварт	мян.төг	748.1	750.0	8,349.2	(7,599.2)	1,113.2
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	20,630.0	2,114.9	-	2,114.9	-
8	Нийт ажиллагсдын тоо	Хүн	41.0	41.0	39.0	2.0	95.1
9	Нийт цалингийн сан	мян.төг	661,558.3	449,185.0	522,884.3	(73,699.3)	116.4
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.1	1.0	1.3	(0.3)	129.3
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	-	85,000.0	-	85,000.0	-
12	Нийт авлага	мян.төг	34,020.9	10,255.5	38,517.0	(28,261.5)	375.6
13	Нийт өглөг	мян.төг	105,655.0	16,789.5	333,159.1	(316,369.6)	1,984.3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, байгууллагын онцлогт нийцсэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан, үйл ажиллагаандаа ашиглан ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн. Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, байгууллагын НББ-ийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулан ашигладаггүй байна.

Захирлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар “Дотоод хяналтын комисс байгуулах тухай” тушаалаар дотоод хяналтын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2021 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулах 9 ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг улирал бүр тайлагнасан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг, суурь үзүүлэлтийг 2021 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлын 1,855,520.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,832.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20,874.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний зорилго нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан зам засвар арчлалтын гэрээ болон хувьцаа эзэмшигчдийн хурлын баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг биелүүлж ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Зам тээвэр, хөгжлийн яам, хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 19.4 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн

өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц оновчтой, чиг үүргийн давхардал үүсээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Касс дахь мөнгө	1,902.2	115.1	(1,787.1)
Харилцах дансанд дах мөнгө	31,960.7	37,889.0	5,928.3
Дансны авлага	19,085.9	19,085.9	-
Татвар, НДШ-ийн авлага	1,029.8	13,920.9	12,891.1
Бусад авлага	13,905.2	5,510.2	(8,395.0)
Бараа материал	85,101.8	25,656.2	(59,445.6)
Үндсэн хөрөнгө	638,048.8	598,934.0	(39,114.8)
Биет бус хөрөнгө	40,768.5	40,619.7	(148.8)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	831,802.9	741,731.0	(90,071.9)
Дансны өглөг	19,763.3	184,221.8	164,458.5
Татварын өглөг	57,729.9	39,454.1	(18,275.8)
НДШ-ийн өглөг	28,161.7	109,483.2	81,321.5
Өмч: а) төрийн	1,018,908.8	1,018,908.8	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,244.5	25,244.5	-
Эздийн өмчийн бусад хэсэг	40,270.0	40,270.0	-
Хуримтлагдсан ашиг	(358,275.3)	(675,851.4)	(317,576.1)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	831,802.9	741,731.0	(90,071.9)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 115.1 мянган төгрөг, харилцах дансанд 37,889.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, валютын харилцах дансгүй байна. Шалгагдагч байгууллага нь Чингисхаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршуулсан мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл НӨАТ-ын авлага 13,920.9 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 19,085.9 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 210.2 мянган төгрөг, ажилчдаас авах цалингийн урьдчилгаа 5,300.0 мянган төгрөг, нийт 38,517.0 мянган төгрөгийн авлагын

үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 38,517.0 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн болон найдваргүй авлагагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,656.2 мянган төгрөг болж 59,445.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд сэлбэг хэрэгсэл, тослох материал, түүхий эд материалын зарцуулалт өссөнөөс шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 343,176.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 402,630.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 25,656.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, ашиглалтгүй бараа материалын үлдэгдэлгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 598,934.0 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 39,114.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2021 оны 493 дугаар тогтоолоор нийт 26,281.3 мянган төгрөгийн өртөгтэй, 13,140.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1 ширхэг SLB-10 маркийн асфальт бетон завод “Увс АЗЗА” ТӨХК-д балансаас баланст шилжүүлснээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дансанд 2,975.0 мянган төгрөгийн зохиогчийн эрх, 40,270.0 мянган төгрөгийн газар эзэмших, ашиглах эрх бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа байгууллагад төлөх өглөг 179,606.8 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 109,483.2 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 39,454.1 мянган төгрөг, ажилчидтай холбоотой үйлдвэрчний эвлэлийн хороонд төлөх өглөг 4,615.0 мянган төгрөг, нийт 333,159.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тусган тайлагнасан байна. Урт хугацаат өр төлбөр дансанд үлдэгдэлгүй байна. Тайлант оны эхэнд байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хувь хүнээс нийт 31,000.0 мянган төгрөгийн зээл авсныг тайлант ондоо төлж барагдуулсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 623 дугаар тушаалаар Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,867,272.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,855,523.3 мянган төгрөгөөр, 11,749.5 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 85,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 951,078.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,213,819.6 мянган төгрөгийн зардал гарган, 262,741.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 951,078.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 916,194.8 мянган төгрөг буюу 50.1 хувиар тасарсан нь улсын болон орон нутгийн чанартай зам засварын ажлын санхүүжилт буурснаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,213,819.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 641,703.7 мянган төгрөг буюу 34.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь улсын болон орон нутгийн чанартай зам засварын ажлын санхүүжилт буурч, холбогдох зардал буурснаас гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 262,741.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 274,491.1 мянган төгрөгөөр илүү байгаа нь зам засварын ажлын түүхий эд материал, шатахууны үнэ өссөнөөс нөлөөлж байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 421,783.4 мянган төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, шилэн дансанд мэдээлбэл зохих 166 мэдээллээс 161 мэдээллийг хугацаандаа, 5 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 242,716.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 17,624.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 26,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгасан, 198,591.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 172,300.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-					
Албан шаардлага	-	-					
Зөвлөмж	3	172,300.0	2	172,300.0	1	-	66.7
Нийт дүн	3	172,300.0	2	172,300.0	1	-	66.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувийн хэрэгжилттэй, 1 алдаа зөрчил давтан гарч байгаа тул давтан гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн шийдвэрлэлт, бараа материалын ажил гүйлгээ, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 456,362.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 810.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,247.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 89,179.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 365,126.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 455,552.5 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 27,832.8 мянган төгрөгийн материаллаг түвшнээс 427,719.7 мянган төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 810.3 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

1. Тайлант жилийн орлогын тайланг тулгахад ААНБОАТ-ын тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг, Санхүүгийн орлогын тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг/алдагдлаас 810.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-г "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,247.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацааны ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад баяр ёслолын арга хэмжээнд төсөвлөсөн зардлаас архи, согтууруулах ундаанд 1,247.2 мянган төгрөг зарцуулсан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан зардлыг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

Аудитаар 89,179.3 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг тайлант оны гүйцэтгэлтэй тулган шалгахад цалингийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 73,699.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь : Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"

гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн батлагдсан төлөвлөгөөт зардлыг хэтрүүлэн зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Захирлын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн өдрийн А/70 дугаар тушаалаар Авто замчдын Хүндэтгэлийн хүлээн авалтын зардалд 5,000.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 83 дугаар тушаалаар Шилдэг ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах зардалд 5,480.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 85 дугаар тушаалаар Шинэ жилийн үйл ажиллагаа, гарын бэлэг, хүлээн авалтад 5,000.0 мянган төгрөг, нийт 15,480.0 мянган төгрөгийг тэмдэглэлт ой, баяр ёслол, шагнал урамшуулалд зарцуулсан нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн дээд шатны байгууллагын баталсан шийдвэрийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Захирлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/90 дугаар "Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын комисс томилох тухай" тушаалаар тооллогын комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж, үр дүнг хэлэлцэн баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 166 мэдээллээс 161 мэдээллийг хугацаандаа, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага

өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 25 нэр төрлийн 198,513.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 2021 оны 10-12 сард нийт 106,374.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа анхан шатны баримтыг олгосон, хүлээн авсан гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж, бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэж, тайлагнахгүй байх

3. Эздийн өмчтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн хөрөнгийн дүн Санхүүгийн тайлан дахь өмчийн дүнгээс 60,238.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд тусгагдсан өмчийн дүнг Улсын бүртгэлд бүртгүүлэн, баталгаажуулах арга хэмжээ авч ажиллах

4. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичиг ашигладаггүй, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн боловсруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулий 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагаа, онцлог, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журамд нийцсэн НББ-ийн бодлогын баримт бичиг бэлтгэж, ашиглах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
					Үүнээс		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Тайлант хугацааны ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад баяр ёслолын арга хэмжээнд төсөвлөсөн зардлаас архи, согтууруулах ундаанд 1,247.2 мянган төгрөг зарцуулсан	Төлбөрийн акт тогтоов	1	1,247.2			1	1,247.2						
2	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Захирлын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн өдрийн А/70 дугаар тушаалаар Авто замчдын Хүндэтгэлийн хүлээн авалтын зардалд 5,000.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 83 дугаар тушаалаар Шилдэг ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах зардалд 5,500.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 85 дугаар тушаалаар Шинэ жилийн үйл ажиллагаа, гарын бэлэг, хүлээн авалтад 5,000.0 мянган төгрөг, нийт 15,500.0 мянган төгрөгийг тэмдэглэлт ой, баяр ёслол, шагнал урамшуулалд зарцуулсан	Албан шаардлага хүргүүлэв	1	15,480.0					1	15,480.0				
3	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Захирлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/90 дугаар "Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын комисс томилох тухай" тушаалаар тооллогын комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй	Албан шаардлага хүргүүлэв	1	-					1	-				
4	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг тайлант оны гүйцэтгэлтэй тулган шалгахад цалингийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 73,699.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан	Албан шаардлага хүргүүлэв	1	73,699.3					1	73,699.3				
5	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 25 нэр төрлийн 195,513.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	Зөвлөмж өгөв	1	198,513.7								1	198,513.7	
6	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/	Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 2021 оны 10-12 сард нийт	Зөвлөмж өгөв	1	106,374.3								1	106,374.3	

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		НА-СТА-ТӨА	106,374.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа анхан шатны баримтыг олгосон, хүлээн авсан гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж, бүртгэж тайлагнасан															
7	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн хөрөнгийн дүн Санхүүгийн тайлан дахь өмчийн дүнгээс 60,238.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна	Зөвлөмж өгөв	1	60,238.1											1	60,238.1
8	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичиг ашигладаггүй, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн боловсруулаагүй байна	Зөвлөмж өгөв	1	-											1	-
9	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Тайлант жилийн орлогын тайланг тулгахад ААНБОАТ-ын тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг, Санхүүгийн орлогын тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг/алдагдлаас 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	Залруулав	1	810.3	1	810.3										
ДҮН					9	456,362.9	1	810.3	1	1,247.2	3	89,179.3	-	-	4	365,126.1		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨА-2022/07/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 166 мэдээллээс 161 мэдээллийг хугацаандаа, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	Албан шаардлага хүргүүлэв													1	-
ДҮН					1	-											1	-
НИЙТ ДҮН					10	456,362.9	1	810.3	1	1,247.2	4	89,179.3	-	-	4	365,126.1		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn